



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/1455

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн
төвийн барилга данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1099 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн салбар амбулаторийн барилга шинээр барихтай холбогдуулан Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2020 оны 02-07-091/1068 тоот дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 226,395,624.00 /хоёр зуун хорин зургаан сая гурван зуун ерэн таван мянга зургаан зуун хорин дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв /Л.Баярхүү/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлсэн 8,646,200.0 /найман сая зургаан зуун дөчин зургаан мянга хоёр зуун/ төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн
...1/185... дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Биег хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэх өртөг |
|----------|--|---------------|-------------|-------------|----------------|----------------|--------------------|----------------|
| 1 | Сүхбаатар дүүргийн салбар амбулаторийн барилга-1 | 63 | м2 | 1400 | 226,395,624.00 | 226,395,624.00 | 42,449,179.50 | 183,946,444.50 |
| Нийт дүн | | | | | | 226,395,624.00 | 42,449,179.50 | 183,946,444.50 |